

| № | Хэлэлцэх асуудал                                                                                                                                                                              | Хугацаа /минут/ | Асуудал танилцуулах албан тушаалтан | Гарах шийдвэр |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-------------------------------------|---------------|
| 1 | Suzuki Vitara суудлын авто машиныг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/361 дүгээр захирамжаар балансаас балансад шилжин ирснийг байгууллагын өмчид бүртгэх тухай | 30              | Зөвлөлийн дарга                     | Тэмдэглэл     |

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН  
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025.04.09

Дугаар 05

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 10:00 цагт эхэлж 10:30 цагт дуусгав.

Хуралд:

Зөвлөлийн дарга Н.Пүрэвсүрэн

Гишүүд: О.Чулуун-Эрдэнэ

Г.Ганцэцэг

Э.Ундармаа нар оролцов.

Хурлын ирц 80 хувь. /хурлын гишүүн Э.Энгүүн жирэмсний болон амаржсаны чөлөөтэй/

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:** SUZUKI VITARA суудлын авто машиныг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/361 дугаар захирамжаар балансаас балансад шилжин ирснийг байгууллагын өмчид бүртгэх тухай

**СОНССОН НЬ:** Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн “Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай” А/361 дүгээр захирамжаар 64,000,000.00 (жаран дөрвөн сая) төгрөгийн үнэ бүхий Suzuki grand Vitara маркийн тээврийн хэрэгслийг манай байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэжээ.

Н.Пүрэвсүрэн: Дээрх захирамжийн дагуу өнөөдөр өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд 0965 УБҮ улсын дугаартай Suzuki grand Vitara маркийн 196,442 км гүйлтийн заалттай авто машиныг хүлээн авлаа.

О.Чулуун-Эрдэнэ: Авто машины зургийг хэд хэдэн талаас нь дарж баталгаажуулсан. Гадна харагдах байдал цэвэр, хар саарал өнгөтэй, өвлийн 4 дугуйтай, запас дугуйтай. Буруу талын хойд гэрлийн шил жижиг хагарсан байдалтай байсан.

Э.Ундармаа: Урд талын гупр засвар орсон байдалтай, дотор үзэмж салон цэвэр, баруун хойд талын хаалга жижиг зураастай байсан.

Н.Пүрэвсүрэн: НЗД-ын захирамжаар балансаас балансад шилжин ирсэн авто машиныг хүлээн авч байгууллагын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрч байна. Саяхан бид олон жил ашигласан авто машинаа актлах хүсэлт гаргаж Өмчийн харилцааны газарт өгсөн учраас бидэнд авто машин зайлшгүй хэрэгцээтэй гэж үзэж байна. Гишүүд санал байна уу?

Г.Ганцэцэг: Саналгүй, зөвшөөрч байна. Холбогдох журмын дагуу байгууллагын хөрөнгөд бүртгэж авъя.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:** 0965 УБҮ улсын дугаартай Suzuki grand Vitara авто машиныг байгууллагын хөрөнгөд журмын дагуу бүртгэн авч ашиглахыг нярав Э.Ундармаад, хөрөнгө бүртгэлд авсан тухай шийдвэрийн хуулбарыг Өмчийн харилцааны газарт хүргүүлэхийг Ахлах нягтлан бодогчид үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Тэмдэглэл хөтөлсөн:

Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/

